



144

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/114

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Шинэ сэргэлтийн бодлогын 6.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/05 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үүлэн технологид суурилсан цахим шуудан, портал систем (оффис 365) нэвтрүүлэх байгууллагуудаас үнийн санал авч, сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Н.Ганзориг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Батнасан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн
мэргэжилтэн)

Д.Дөмөгтүшиг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн)

Нарийн бичгийн
дарга:

Н.Цэрмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

2. Ажлын хэсгийн гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх,
зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн

дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Дээрх сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Н.Цэрмаа)-д үүрэг болгосугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* Б.БАЯРСҮХ

